

ЭНЭТХЭГ, МОНГОЛ ОЮУН САНААНЫ ХӨРШҮҮД

Доктор О.Нямдаваа

Монгол Энэтхэг маш эртний хэлхээ холбоотой байж хамтын ажиллагаа явуулж ирсэн түүхтэй. Энэ харилцаа 2700-3000 жилийн түүхтэй гэдгийг Монгол, Энэтхэгийн эрдэмтэд тэмдэглэн үлдээжээ. Хоёр орны эртний хэлхээ холбоо олон зүйл дээр түшиглэж байсны нэг нь оюун санааны харилцаа юм. Манай хоёр улс хэдийгээр хил залган оршдоггүй ч манайд Энэтхэгээс нэвтэрч байсан олон сайхан эртний ном судар, гүн ухаан, шашин соёлын салбарууд нь хоёр орныг оюун санааны хөрш болгожээ. Үүнийг Энэтхэг, Монголын эрдэмтэд, улс төрчид хүлээн зөвшөөрч одоо тэр нь бодит зүйл болон хөгжиж байна. Энэхүү оюун санааны хөршийн холбоо харилцаа бол тэр болгон бусад улс орны хооронд байдаггүй бөгөөд манай хоёр орны хувьд олон зуун жилийн өмнөөс бий болж үүссэн түүхэн аргамжааны алтан зангилаа юм.

Бурханы шашин Энэтхэгээс Төв Ази, Жамму Кашмираар дамжин Монголд шууд нэвтэрсэн тухай түүхийн олон ном зохиол гадаад оронд байх юм билээ. Тэдний заримд Бурханы шашны бага, их хөлгөн хоёул манайд дэлгэрсэн талаар тэмдэглэсэн нь буй.

Монгол лам нар эрдэм ном өвөрлөн эх нутагтаа буцан ирэхээр Энэтхэг оронд V-VII зууны үед очиж Наландагийн их сургуульд Буддын гүн ухаан, одон орон, яруу найргийн онол, аюурвэд-анагаах ухаан зэргийг суралцаж мэргэжлээ дээшлүүлэхээр очдог байсан талаар Хятадын мөргөлч эрдэмтдийн тэмдэглэлд үлджээ. Тэдний дотор 29 орны оюутан байсныг нэгэн адил дурьдсан байдаг. Тэд буцаж ирснийхээ дараа Буддын гүн ухаан, эм барих, одон орны судлал, Энэтхэгийн соёл түүх, урлаг, утга зохиолыг Монгол нутагтаа түгээн дэлгэрүүлдэг байжээ. Энэ уламжлалыг өнөөдөр улам баяжуулан хөгжүүлэх бодлогыг манай хоёр орны тор, засгийн газар баримтлан явуулж, улмаар манай олон оюутан Энэтхэгийн их, дээд сургуульд жил бүр хорь гучуулаа айлын талын зардлаар суралцах болсон нь талархуунтай.

Энэтхэгийг дэлхийн соёл иргэншлийн өлгий орнуудын нэг гэдэг билээ. Тэгвэл тэр өлгий нутгаас ийнхүү олон сайхан ВЕДА-нууд Монголын тал нутаг тийш намуухан салхилсаар манай ард түмний шүтэн биширдэг ном зохиол, онол сургаал болон манай хөрс шороонд монголчлогдон хувирч, түүнийгээ бид номнол болгосоор ирсэн билээ. Эртний их хөлгөн судар “Ганжуур”, “Данжуур” болон манайхны ширээний ном болж байсан “Бигармижид хааны үлгэр”, “Арж Бүрж хааны үлгэр”, “Шидэт хүүрийн үлгэр”, “Гучин хоёр модон хүний үлгэр”, “Үүлэн зардас”, “Таван сургаал-Банчатагтар”, “Үлгэрийн далай”, Дандины “Зохист аялгууны толь”, “Рамаяана”, “Гэсэр хааны тууж”, “Алтангэрэл судар” зэрэг нь бүгд Энэтхэг орноос гарал үүсэлтэй бөгөөд монголчуудын үе үеийнхний амтархан уншдаг зохиолууд билээ. Эдгээрээс үүдэн манай хоёр орныг оюун санааны хөрш гэж мэргэд томьёолон хэлсэн нь утга учиртай нүдээ олсон оновчтой дүгнэлт билээ.

Монгол Энэтхэгийн эртний хэлхээ холбоог харуулсан олон сайхан зүйлүүд өнөөдрийг хүртэл үлдсэн байдаг. Түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан үзэх явдал шаардлагатай байна. Тэдний заримаас дурьдвал Дели хотод байдаг Монголзури гэдэг район, Энэтхэгийн зүүн хойт нутаг болон Гималайн сав газраар нутаглан амьдардаг хүмүүсийн ахуй амьдрал олон талаар монголчуудтай ойролцоо, төсөөтэй байдаг. Тэд ч өөрсдийгөө монголчуудын удам угсаа гэж үздэг. Хэрэйд аймгаас нүүдэллэн очсон хүмүүс ч тэдний дотор байдгийг цухас дурьдахал хангалттай байна.